



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2019

Э-сонин

1-Р САР

66-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2019.01.01-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	22
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	3,748,197,716.28
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	3,296,902,126.28
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	451,295,590
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	18,882,008
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	18,877,656
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	4,352
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	3,680


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	216
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	11
Хувийн өмчийн	187
I ангилал	13
II ангилал	42
III ангилал	167

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	61
Үүнээс: Брокер, Дилер	52
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.01.31-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	10,233,946	1,207,200,801	6,919,428	1,655,196,391	2,160,699,278
2	Бумбат-Алтай ХХК	2,888,344	1,003,273,217	4,330,848	1,003,273,217	2,041,575,123
3	БиДиСек ХК	991,224	309,429,659	1,319,618	311,429,659	827,439,494
4	Голомт Капитал ХХК	783,042	290,941,519	727,145	290,941,519	443,101,365
5	Ард секьюритиз ХХК	444,508	161,807,355	443,482	161,807,355	320,355,507
6	Ти Ди Би Капитал ХХК	689,975	168,190,667	731,764	168,190,667	296,866,834
7	Стандарт инвестмент ХХК	344,497	103,294,815	1,271,238	103,294,815	264,974,703
8	Гаули ХХК	430,584	105,623,908	481,327	106,923,908	166,968,083
9	Новел инвестмент ХХК	320,444	52,862,283	319,758	52,862,283	148,907,997
10	Апекс Капитал ҮЦК	219,170	71,210,630	455,382	71,210,630	146,992,378
11	Гүүдсек ХХК	887,997	71,429,266	124,554	71,429,266	117,057,637
12	Дархан брокер ХХК	8,718	17,486,246	61,282	17,486,246	65,102,760
13	Централ секьюритиз ҮЦК	132,309	52,723,039	1,011	52,723,039	52,893,139
14	Батс ХХК	120,000	8,059,664	483,593	8,059,664	50,698,499
15	Ард капитал групп ХХК	51,994	17,422,019	81,399	17,422,019	45,405,009
16	Монсек ХХК	151,918	29,431,211	66,074	29,431,211	44,819,553
17	Гранддевелопмент ХХК	10,029	7,317,690	432,472	7,317,690	38,493,429
18	Эм Ай Би Жи ХХК	38,624	11,198,230	3,745	11,198,230	34,640,180
19	Таван богд ХХК	420	139,240	79,064	139,240	29,671,780
20	Зэргэд ХХК	43,629	18,703,971	33,343	18,703,971	28,256,018

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.01.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	APU	АПУ	1,862,556	1,143,189,717	650	590	-4.07	635.11
2	LEND	ЛЭНДМН ББСБ	14218237	1,009,105,919	76	65	4.75	59.50
3	GOV	ГОВЬ	1345274	455,881,511	358	320	-0.80	258.39
4	AIC	АРД ДААТГАЛ	158407	114066622.2	750	680	-9.06	17.51
5	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	17,627	89,799,036	5,300	4,810	-2.86	31.84
6	TTL	ТАВАН ТОЛГОЙ	12,261	88,811,585	7,525	6,980	-2.91	368.66
7	SUU	СҮҮ	380,317	77,777,347	210	200	-0.55	69.79
8	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	262,610	70,799,843	298	260	11.33	15.14
9	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	107270	58616492	580	520	-10.34	2.08
10	ITLS	АЙТҮҮЛС	252,312	26,128,758	112	100	-6.81	3.58
11	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	199	23,214,000	125,000	110,000	0.00	7.19
12	JIV	ЖИНСТ-УВС	10,149	20,614,092	2,300	1,700	-20.97	3.08
13	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	33728	20205244.5	700	580	-12.28	59.75
14	BDS	БИ ДИ СЕК	21,875	19,887,516	950	905	0.66	15.47
15	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	1,158	14,425,300	12,480	12,450	-1.19	2.03
16	TCK	ТАЛХ ЧИХЭР	648	12,357,300	20,000	19,000	-1.55	19.45
17	BAN	БАГАНУУР	3,735	5,369,878	1,500	1,300	-1.46	28.40
18	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	10,664	5,201,310	520	454	-9.00	16.75
19	NEH	ДАРХАН НЭХИЙ	274	4,664,410	18000	15000	-11.06	17.70
20	TAN	ТАХЬ-КО	344	4,355,000	13,400	12,200	-8.96	14.52



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2019-01-01	2019-01-31		
1	ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ	4	460.00	650.00	190.00	41.30
2	УВС ЧАЦАРГАНА	200	350.00	450.00	100.00	28.57
3	ТАВ	43	10,000.00	12,070.00	2,070.00	20.70
4	ХАЙ БИ ОЙЛ	2,473	52.00	61.80	9.80	18.85
5	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	16,000	132.00	151.80	19.80	15.00
6	ГАН ХЭРЛЭН	12	4,413.00	5,070.00	657.00	14.89
7	МОНГОЛ БАЗАЛЫТ	262,610	241.08	268.40	27.32	11.33
8	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	2	270.00	300.00	30.00	11.11
9	ГУТАЛ	200	16,000.00	17,000.00	1,000.00	6.25
10	ЛЭНДМН ББСБ ХК	14,218,237	71.00	74.37	3.37	4.75
11	ДӨРВӨН-УУЛ	36	1,300.00	1,350.00	50.00	3.85
12	ТҮШИГ УУЛ	2	530.00	550.00	20.00	3.77
13	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	1,896	834.77	850.00	15.23	1.82
14	БИ ДИ СЕК	21,875	904.05	910.00	5.95	0.66
15	НАКО ТҮЛШ	850	109.70	110.00	0.30	0.27
16	ИХ БАРИЛГА	1	3,099.00	3,100.00	1.00	0.03
17	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	1,354	120.00	120.00	0.00	0.00
18	МОНИНЖБАР	650	95.00	95.00	0.00	0.00
19	ШАРЫН ГОЛ	502	1,801.00	1,801.00	0.00	0.00
20	БӨХӨГ	481	3,300.00	3,300.00	0.00	0.00

Ханшийн бууралттай хувьцаа

/2019.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2019-01-01	2019-01-31		
1	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	61	8,500.00	5,300.00	-3,200.00	-37.65
2	МОНГОЛ САВХИ	833	724.50	492.00	-232.50	-32.09
3	ДАРХАН ХӨВӨН	54	13,000.00	9,000.00	-4,000.00	-30.77
4	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	251	1,600.00	1,200.00	-400.00	-25.00
5	МЕРЕКС	1,035	31.97	24.00	-7.97	-24.93
6	ЦАГААНТОЛГОЙ	30	2,776.00	2,100.00	-676.00	-24.35
7	ЖИНСТ-УВС	10,149	2,341.00	1,850.00	-491.00	-20.97
8	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	610	545.00	441.00	-104.00	-19.08
9	МАТЕРИАЛИМПЕКС	177	9,490.00	8,000.00	-1,490.00	-15.70
10	АВТО ЗАМ	7	5,180.00	4,500.00	-680.00	-13.13
11	ШИВЭЭ ОВОО	321	2,295.00	2,000.00	-295.00	-12.85
12	МОНГОЛ ШУУДАН ХК	33,728	684.03	600.00	-84.03	-12.28
13	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	1,223	425.00	372.90	-52.10	-12.26
14	МОННООС	23	2,500.00	2,200.00	-300.00	-12.00
15	ДАРХАН НЭХИЙ	274	18,000.00	16,010.00	-1,990.00	-11.06



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 28 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж нь 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Монгол улсад төрийн өмч хувьчлалыг явуулах, хөрөнгийн зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдаж байсан билээ. Дээрх зорилгын хүрээнд өмч хувьчлалыг ажлыг 1992-1995 онуудад зохион байгуулж, үүний дүнд 1.2 сая орчим хөрөнгө оруулагч бий болж, 475 улсын үйлдвэрийн газрыг амжилттай хувьчилсан бөгөөд 1995 оноос хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлж, хувьцаагаа хоорондоо арилжаалдаг хөрөнгийн бирж гэдэг жинхэнэ утга агуулгаараа хөгжих үндэс суурь тавигдсан билээ.

28 жилийн ойн арга хэмжээг нээж МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай "...450 гаруй жилийн түүхтэй Лондонгийн хөрөнгийн бирж зэрэг бусад биржүүдтэй харьцуулахад дөнгөж байгуулагдаж байгаа мэт боловч манай бирж нь олон улсын жишигт нийцсэн программ хангамжтай болж хууль эрх зүйн томоохон шинэчлэлүүдийг хийж чадсан билээ. 2017 онд 859 тэрбум төгрөгийн арилжаа хийж түүхэн дээд амжилтаа тогтоосон бол 2018 онд зөвхөн хувьцааны арилжаагаар 210 тэрбум төгрөгийн, 28 жилийн дүнгээр 1 их наяд гаруй төгрөгийн арилжаа хийжээ. Мөн анхны давхар бүртгэл болон хамгийн олон IPO хийгдсэн зэрэг түүхэн амжилтуудаар ойгоо угаж байна. Бид цаашид зах зээлийг шинэ түвшинд хүргэхээр ажиллах болно" гэж хэллээ. Ойн арга хэмжээг тохиолдуулан МХБ-ийн 5824 дэх арилжааг нээж биржид 28 жил ажиллаад байгаа Захиргааны албаны ахмад ажилтан Г.Энхболд арилжааны цан цохилоо.

"АРД КРЕДИТ ББСБ" КОМПАНИ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/133 тоот тушаалаар "Ард Кредит ББСБ" ХК-ийн нийт 280,000,000 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн II ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 03 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 25 хувь буюу 70 сая ширхэг хувьцааг нийтэд санал болгон худалдах зөвшөөрлийг олгосон байна.

Тус компани олон нийтэд арилжаалах хувьцааны 50 хувь буюу 35 сая ширхгийг стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн аргаар буюу нэгжийн үнийг 70 төгрөгөөр, үлдсэн 50 хувь буюу 35 сая ширхгийг захиалгын бүртгэлийн аргаар нэгжийн үнийг 70-85 төгрөгөөр нийтэд санал болгон худалдаж, нийт 4.9-5.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй

бөгөөд үүнийг зээлийн эх үүсвэрийг санхүүжүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зарцуулах юм.

Энэхүү хувьцааны андеррайтингийн үйлчилгээг "Ард Капитал групп ҮЦК" ХХК, аудитын үйлчилгээг "Далай Ван Аудит" ХХК, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг "Өмгөөллийн И Эл Си" ХХН, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг "БДО Аудит" ХХК тус тус үзүүлж байна.

"ТҮМЭН ШУВУУТ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБОГДУУЛАН ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн "Түмэн шувуут" ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Түмэн шувуут" ХК-ийн Үүсгэн байгуулагч Л.Эрхэмбаяр, "Түмэн шувуут" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Болд, "Голомт Капитал ҮЦК" ХК-ийн Гүйцэтгэх захирал Мөнхжаргал нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,892 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

Түмэн Шувуут компани нь анх 2004 онд 18 ажилтан, 20,000 өндөглөгч тахиатайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол эдүгээ 160 гаруй ажилтан, 310,000 гаруй өндөглөгч тахиатайгаар, монголын өндөг үйлдвэрлэлийн салбарын 53 хувийг дангаар гүйцэтгэж буй салбартаа тэргүүлэгч компани юм.

Тус компани нь өндөглөгч тахианы аж ахуй болон усалгаатай газар тариалан, гурил тэжээлийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх болон махны чиглэлийн тахианы аж ахуй, органик бордооны үйлдвэрийг шинээр барих зорилгоор нийт хувьцааныхаа 25 хувь буюу 50,000,000 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна. Үнэт цаасны худалдан авах захиалгыг 2018 оны 1 дүгээр сарын 15-наас эхлэн Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 15:00 цаг хүртэл хүлээн авлаа.



ГАДААДЫН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДАД ДАВХАР БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013 онд шинэчлэн батлагдаж, Санхүүгийн зохицуулах хорооны болон Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ийн дүрэм журмуудад үнэт цаасны давхар бүртгэлийн журмын зохицуулалтыг 2018 онд нэвтрүүлснээр үнэт цаасыг давхар бүртгэх хууль эрхзүйн орчин бүрэн бүрдсэн билээ. Үүний дагуу МХБ нь 2018 оны 6 дугаар сард хамгийн анхны давхар бүртгэлийн үнэт цаас буюу Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ ресурс девелопмент корпорейшн-ийн хувьцааг бүртгэж арилжаалсан билээ.

Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын хувьд үнэт цаасаа олон нийтэд нээлттэй гаргаж арилжаалах нь ард иргэдтэй төслийн үр ашгийг хуваалцах, олон нийтийн дунд компанийн үйл ажиллагааны талаарх ойлголт дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой болох нь эхний давхар бүртгэгдсэн компанийн жишээнээс харагдаж байгаа билээ. Иймд бусад уул уурхайн компаниудад энэхүү боломж, ач холбогдлын талаар танилцуулах үүднээс “Үнэт цаас давхар бүртгүүлэх боломж, анхны давхар бүртгэгдсэн компанийн туршлагаас хуваалцах семинар”-ыг МХБ-ээс өнөөдөр зохион байгууллаа. Гадаадын биржид бүртгэлтэй компаниудын хувьд үнэт цаасны бүртгэлийн анхны шалгуур шаардлага болон хувьцаат компанийн тогтмол үүргийн хэрэгжилтийн хувьд хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх боломжтой, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг өндөр түвшинд хангадаг 26 биржийн аль нэгэнд бүртгэгдсэн тохиолдолд гадаадын биржийн дүрэм журмыг дагаж мөрдөхийг зөвшөөрдөг болохыг МХБ-ээс танилцууллаа.

Анхны давхар бүртгэгдсэн Эрдэнэ ресурс девелопмент компанийн хувьд үнэт цаасаа дотоодын биржид гаргаснаар үйл ажиллагаа явуулдаг сумдын ард иргэдэд үнэгүй хувьцаа эзэмшүүлсэн, ард иргэдийн ойлголт дэмжлэг нэмэгдсэн бөгөөд үнэт цаас гаргах ажиллагаа хүндрэл чирэгдэлгүй 4 орчим сарын хугацаанд явагдсан зэргээр туршлагаасаа бусад компаниудтай хуваалцлаа.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МЭДЭГДЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.1-д “Хороо нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих”, 6.1.3-д “санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих “ бүрэн эрхтэй гэж хуульчилсан. Түүнчлэн Хороонд санхүүгийн зах зээлийн хөгжил, тогтвортой байдлыг хангах чиг үүргийг оноосон

бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Хороо үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж, зээлийн хоршооны зах зээл, эдгээр салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэн баталгаажуулж, хянан зохицуулж ажилладаг.

Хурдацтай хөгжиж буй мэдээллийн технологи, интернэт, олон нийтийн сүлжээ ашиглан өндөр хүү амлаж, иргэдээс хөрөнгө, мөнгө татах явдал цөөнгүй гарсаар байна. Тухайлбал, 2018 оноос “High Level Investment” ХХК, “Новел инвест” ХХК зэрэг байгууллага зохицуулалтгүй, хууль бус үйл ажиллагааг “эрсдэлгүй хөрөнгө оруулалт”, “даатгагдсан хөрөнгө оруулалт” гэх мэтээр сурталчлан явуулах боллоо. Холбогдох хууль тогтоомжоор “хөрөнгө оруулалтын хэрэгсэл”-ийг Хороо тогтоох төдийгүй үнэт цаас, нэгж эрх зэрэг санхүүгийн аливаа хэрэгслийг Хороо бүртгэж, зөвшөөрөл олгохоор хуульчилсан байдаг. Иймд Хорооны зохицуулалтад хамаараагүй, холбогдох зөвшөөрөл, эрх аваагүй хууль бус үйл ажиллагаагаа таслан зогсоохыг дээрх байгууллагуудад хариуцлагатайгаар мэдэгдэхийн сацуу санхүү, хөрөнгө оруулалтын аливаа хэрэгсэлд хөрөнгө оруулахдаа тусгай зөвшөөрөлтэй эсэхийг сайтар нягталж, эрх зөвшөөрөлгүй, луйврын үйл ажиллагаанд өртөж хохирохоос сэргийлэхийг нийт ард иргэддээ анхааруулж байна.

Иргэн Та өөрийн итгэл үнэмшлээр санхүүгийн аливаа үйл ажиллагаа, хэрэгсэлд хөрөнгө оруулах нь нээлттэй ч Хорооны зохицуулалтгүй, зөвшөөрөгдөөгүй хэрэгслийг сонгосон тохиолдолд ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, хохирлыг өөрөө бүрэн хариуцахыг албан ёсоор мэдэгдэж байна.

"ТОП-20" ИНДЕКСИЙН САГС ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын дагуу ТОП-20 индексийн багцыг 2019 онд бүрдүүлэх үнэт цааснуудыг шалгаруулж, сагсыг шинэчлэв.

2018 оны үзүүлэлтээр өмнөх сагсанд багтаж байсан 11 компани хэвээр үлдэж, “Баянгол зочид буудал”, “Шивээ овоо”, “Ариг гал”, “Адуун чулуун”, “Монголын цахилгаан холбоо”, “Шарын гол”, “Хөх ган”, “Материалимпекс”, “Улсын их дэлгүүр” ХК-иуд хасагдаж, шинээр “Хай би ойл”, “Женко тур бюро”, “Жинст-Увс”, “Айтүүлс”, “Лэндмн ББСБ”, “Монгол Базальт”, “Хөвсгөл алтан дуулга”, “Мандал даатгал”, “Ард даатгал” ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.

Шинэчилсэн сагсын дагуу индексийн тооцооллыг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэллээ.



"МОНГОЛ БАЗАЛТ" ХК-ИАС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид 2018 онд шинээр бүртгэгдэж олон нийтээс 6.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Монгол базальт" ХК нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3.6 тэрбум төгрөг буюу татан төвлөрүүлсэн хөрөнгийн 56 хувийг Үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл, шүршдэг базальт технологийн үйлдвэр, үйлдвэрийн автоматжуулалт, механик цехийн шинэчлэлт, центрфуг бул засварын төхөөрөмж, үйлдвэрт ашиглах машин механизм, түүхий эдийн нөөц бэлтгэх, үйлдвэрийн ИТА-ын сургалт хөгжлийн төв байгуулахад зарцуулсан байна.

Үйл явдал

МХБ-Д БҮРТГЭЛТЭЙ "МИК" ХК-ИЙН 100 ХУВИЙН
ОХИН КОМПАНИ "МИК ОССК" ОЛОН УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД 250 САЯ АМ.ДОЛЛАРЫН
БОНД АРИЛЖЛАА

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй "МИК Холдинг" ХК-ийн 100 хувийн охин компани болох "МИК ОССК" ХХК нь 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр 3 жилийн хугацаатай, жилийн 9.75 хувийн хүүтэй нийт 250 сая ам.долларын үнийн дүн бүхий бондыг олон улсын санхүүгийн зах зээлд амжилттай арилжаалсан байна.

Тус компани нь олон улсын үнэлгээний агентлагуудаас "В" үнэлгээтэй байгаа нь Монгол улсын зээлжих зэрэглэлтэй адил түвшинд байгаа бөгөөд Монголын хөрөнгийн биржийн бүртгэлтэй компаниуд дотроос хамгийн анхны олон улсын санхүүгийн зах зээлд бонд арилжаалсан компани боллоо.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN